

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ЕРӨНХИЙ ТОЙМ
2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД
3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
4. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
6. ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
7. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
8. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
9. ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ, ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ
10. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ
11. ШИНЭЛЭГ АЖЛЫН ТУХАЙ
12. ДҮГНЭЛТ

1. ЕРӨНХИЙ ТОЙМ

Тус хэлтэс нь 2021 онд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажилласан.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хуультогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдад сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, сумдын улсын бүртгэгч нарт холбогдох чиглэлийг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан хэлтсийн чиг үүрэгт хамаарах үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд хөтөлбөрийн биелэлтийг аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажиллалаа. Мөн аймгийн засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

2021 онд УБЕГ-ын даргын 26 тушаал, 7 зөвлөмж, 22 чиглэл, албан даалгавар 2, мэдээ судалгаа ирүүлэх тухай хугацаат албан бичиг 28 ирснийг албан хаагчдад танилцуулан хэрэгжилтийг ханган, тайланг хугацаанд нь хүргүүлэн, УБЕГ-с зохион байгуулсан 36 удаагийн цахим болон танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласнаар мэдээ, мэдээллийг цаг тухайд нь авч ажилласан.

Хэлтсийн 35 албан хаагчийн 2020 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд цахимаар хүлээн авч баталгаажуулах, цаасан хэлбэрээр хүлээн авах, бүртгэх хадгалах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллалаа. Төрийн албанд шинээр болон өөрчлөгдөн томилогдсон 5 албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг УБЕГ-т хүргүүлж ажилласан байна.

2. ХЭЛТСЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БУСАД АЖЛУУД

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Улсын бүртгэлийн хэлтсийн хийж хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөөнд туссан ажлууд 100 хувь хийгдэж Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж, ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг УБЕГазарт хүлээлгэн өгч ажиллалаа.

2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хяналтандаа авч хэрэгжилтийг ханган ажиллаж, 2021 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн явцын хяналт шинжилгээний үнэлгээний зөвлөмжийн дагуу, ажил эрчимжүүлэх ажлын хэсгийг хэлтсийн даргын тушаалаар байгуулан эрчимжүүлэх шаардлагатай 5н арга хэмжээг зорилтот түвшинд хүргэхээр хяналтандаа авч, холбогдох ажлуудыг зохион байгуулан ажиллалаа.

Хууль зүй дотоод хэргийн сайд, аймгийн Засаг дарга нарын 2021 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан тус хэлтэст хамаарах заалтыг хяналтандаа авч хэрэгжилтийг ханган, тайланг хүргүүлээ.

Аймгийн засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн онцгой комиссын гишүүнээр ажиллаж 2021 оны эхний хагас жилд 22 удаагийн хуралд оролцож, хурлын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн засаг даргын А/73, А/75, А/103, А/229, А/131, А/133, А/143, А/162 захирамжийн хэрэгжилтийг ханган 2021.02.09-2021.02.14, 2021.03.17-2021.03.19, 2021.03.29-2021.04.09-ний өдрүүдэд хөдөлгөөнт эргүүл хяналтын хуваарь гарган нийт албан хаагчдыг хамруулан ажиллалаа.

Мөн 2021.03.14-ний өдрөөс 2021.03.19-ний өдрүүдэд 2 албан хаагчийг Тариалан сумын Намнангийн арын постонд эргүүлийн үүрэг гүйцэтгүүлээ. Мөн Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Тосонцэнгэл улсын бүртгэгч нар Тариалан сумын Намнангийн арын постонд эргүүлийн үүргийг гүйцэтгэсэн.

Монгол Улсад Ковид-19 цар тахлын улмаас үүсч буй сорилт бэрхшээлийг даван туулахад хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зөв дадал хэвшилд сургах дасгал хөдөлгөөнөөр дархлааг дэмжих зорилготой Аймгийн засаг даргын нэрэмжит “Дасгал хөдөлгөөн хийцгээ” сарын аяны дагуу 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хийгдэх ажлын удирдамж боловсруулан ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшсэн ба аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах арга зүйч Б. Ганчимэгийг урин “Идэвхтэй хөдөлгөөн ба суугаа хэв маяг” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг арилжааны 5 банк, Банк Бус байгууллагын 2, нийт барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг 7 байгууллагын төлөөллийг хүлээн авч Засгийн газраас олгож буй 3%-ийн хөнгөлөлттэй зээл, “ковид”-ийн хол хориотой үед иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх талаар уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтанд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, эд хөрөнгийн улсын ахлах бүртгэгч, ерөнхий нягтлан бодогч нар оролцож чиглэл тус бүрээр хамтран ажиллахаар санал солилцов.

Бүтээлч ажил хийх ажлын хүрээнд нийт хамт олон байгууллагын гадна талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн автомашины зогсоолын тэмдэглэгээ хийж байгууллагыг орчин болон Мөрөн сумын орчны тохижилтыг хийхэд гар бие оролцон 20 ширхэг мод тарьж суулгасан. 2021 оны байгууллагын “Зөв хандлага-зөрчилгүй бүртгэл” уриаг хэвлүүлсэн.

Тус аймаг 2021 оныг “Иргэдээ сонсох жил” болгон зарласантай холбогдуулан хэлтсийн даргын 2021 оны 04 сарын 12-ны өдрийн А/09 тушаалаар ажлын хэсэг байгуулан хийх ажлын төлөвлөгөөг хавсралтаар батлуулан хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгууллаа.

Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлж байгаа иргэдээс сэтгэл ханамжийн 10 асуумж бүхий судалгааг бүртгэлийн төрөл тус бүрээр боловсруулан нийт 80 иргэнээс авч дүнг нэгтгэсэн. Нийт 80 иргэнээс судалгаа авсаны 76 иргэн нь эерэг

санал өгч 95%-тай үнэлэгдсэн. Дээрх судалгаанд тусгасан иргэдийг саналд дүн шинжилгээ хийж өдөр тутмын үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Сумдын улсын бүртгэгч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, бүртгэлийн аливаа алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хяналтын улсын байцаагч Б. Мөнгөнзул, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Л. Номинзул, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Насанбуян нар бүртгэлийн төрөл тус бүрээр онлайн сургалт зохион байгууллаа.

2021оны 5 дугаар сарын 27-ны өдөр Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг арилжааны 5 банк, Банк Бус байгууллагын 2, нийт барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг 7 байгууллагын төлөөллийг хүлээн авч Засгийн газраас олгож буй 3%-ийн хөнгөлөлттэй зээл, “ковид”-ийн хол хориотой үед иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх талаар уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтанд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, эд хөрөнгийн улсын ахлах бүртгэгч, ерөнхий нягтлан бодогч нар оролцож чиглэл тус бүрээр хамтран ажиллахаар санал солилцов.

Нэрлэсэн жилд зохион байгуулагдаж буй ажлын талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор орон нутгийн “Мөрөн телевиз”, “Түмний телевиз”-үүдээр дамжуулан мэдээлэл хийлээ.

Бүтээлч ажлын хүрээнд нийт хамт олон байгууллагын гадна талбайд автомашины зогсоолын тэмдэглэгээ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авто машины зогсоолын тэмдэглэгээг шинэчиллээ. Мөн 2021 оны байгууллагын “Зөв хандлага-Зөрчилгүй бүртгэл” уриаг үйлчилгээний заалны хананд байрлууллаа.

Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний буланг бий болгосон. Цахим үйлчилгээний буланг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлснээр цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia”-ээс иргэд лавлагаа мэдээлэл авах, гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалах зэрэг үйлчилгээ авахаас гадна иргэд интернэт банк, мобайл банк ашиглан үйлчилгээний хураамжаа тушааж баримтаа хэвлэн өгөх боломжоор хангагдсан байна.

Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоныг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажлын хүрээнд 2020 онд 20 сумыг холбосон бол 2021 онд Түнэл, Ханх, Шинэ-Идэр, Тариалан сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбосноор сумдыг онлайн сүлжээнд холбох ажлыг 100 хувь хийж гүйцэтгэсэн.

БЕГ-аас ирүүлсэн “Орон нутаг дахь цахим хуудсын нэгдсэн платормд оруулах бодлого”-ын дагуу Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн албан ёсны вэб сайт хөгжүүлж шинэчлэн мэдээ, мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын хамтарсан 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/1437, А/110 дугаар тушаалын хавсралт, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 чиглэл, зөвлөмжийг үндэслэн тус хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комисс 2021 оны 03 сарын 15-ны өдөр хуралдаж, иргэний баримтын архив, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хадгалагдаж байсан хадгалах хугацаа нь дууссан ИУБ-21, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэр, иргэний үнэмлэх олголтын дэвтэр, гадаад паспорт олголтын

бүртгэлийн дэвтэр, лавлагаа, лавлагаа олгосон бүртгэлийн дэвтэр, хүчингүй болсон гэрчилгээг, архиваас түр олгох баримтын бүртгэлийн дэвтэр архиваас түр олгох эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хувийн хэргийн бүртгэл маягт А-2, Эд хөрөнгө бүртгэлтэй эсэх, барьцаатай эсэх архивын лавлагаа /иргэд аваагүй хугацаа хэтэрсэн лавлагаа/, захиалгын хуудас зэргийг акт үйлдэж устгах шийдвэр гаргасан, үүний дагуу 2021.04.13-ны өдрийн 15:00 – 16:30 цагийн хооронд Мөрөн сумын хогийн цэгт комиссын гишүүдийг байлцуулан шатааж устгалд орууллаа..

Монгол Улсад Ковид-19 цар тахлын улмаас үүсч буй сорилт бэрхшээлийг даван туулахад хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зөв дадал хэвшилд сургах дасгал хөдөлгөөнөөр дархлааг дэмжих зорилготой Аймгийн засаг даргын нэрэмжит “Дасгал хөдөлгөөн хийцгээ” сарын аяны дагуу 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хийгдэх ажлын удирдамж боловсруулан ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшсэн ба аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах арга зүйч Б. Ганчимэгийг урин “Идэвхтэй хөдөлгөөн ба суугаа хэв маяг” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн ЗДТГ-аас “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд www.e-hutuch.mn цахим хуудсыг шинэчилж буйтай холбогдуулан байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллийг шинэчлэн хүргүүлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу УБЕГ-ын хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Ж.Чиймаа, Ш.Уртнасан, хяналтын улсын байцаагч Б.Байгалмаа, Ц.Отгонцэцэг, А.Мөнхцэцэг нарын бүрэлдэхүүнтэй цахим шалгалтыг 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 30-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтын үр дүнгийн талаар албан шаардлага ирүүлсэн. Уг албан шаардлагын дагуу холбогдох арга хэмжээг авч хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан.

Хэлтсийн байрны дотоод нөөц бололцоогоо ашиглан 1 давхарт байрлах ашигладаггүй үйлчлэгчийн өрөөг архивын шаардлагад нийцэхүйц болгон засварлаж архивын тавиур бусад хэрэгслүүдийг байрлуулан хуулийн этгээдийн 3003 хувийн хэрэг баримтыг шилжүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын 05 дугаар тогтоол Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх ажлын хүрээнд орон даяар зохион байгуулагдаж байгаа Аймгийн засаг даргын нэрэмжит “Дасгал хөдөлгөөн хийцгээ” сарын аянд тус хэлтэс тэргүүн байр эзэлж, өргөмжлөл мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлийг тус хэлтсийн биеийн тамирын арга орон тооны бус арга зүйч, иргэний баримтын архивч Б.Оюунцэрэн гардан авлаа.

Албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн үзлэгт хамрууоох ажлыг зохион байгуулж, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх 1, 2 дугаар тунгийн вакцинд хэлтсийн нийт 49 албан хаагч хамрагдсан. Мөн 3-р тунгийн вакцинд 11 албан хаагч сайн дурын үндсэн дээр хамрагдаад байна.

“Хөвсгөл-Цээнэ” эмнэлэгтэй хамтран 35-с дээш насны албан хаагчдыг 7 төрлийн багцын үзлэгт хамруулж мөн Ковид-19 халдварт өвчнөөр өвчилсөн албан хаагчдыг аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран цээжний зураг авхуулан, эмчлүүлэх шаардлагатай албан хаагчдыг давтан эмчилгээнд хамруулж, албан хаагчдад С, D

витамин болон, ковидын эмчилгээний танг хэлтсийн зүгээс авч өгч, дархлааг нь дэмжин ажиллалаа.

Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй ТА9372-МОН “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох төслийн хүрээнд” БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар тус аймгийн 23 сум 1 тосгон бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдож техник тоног төхөөрөмжийн иж бүрэн шинэчлэлт хийгдлээ. Ингэснээр иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй, хүрч үйлчлэх нөхцөл боломжоор хангагдлаа.

Хэлтсийн бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байсан 2011 оны шинэчилсэн бүртгэлийн техник тоног төхөөрөмжийг сумдаас татан авч, акт үйлдэн, УБЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу заасан хугацаанд нь УБЕГ-ын санхүү аж ахуйн хэлтэст хүлээлгэн өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд Эрх зүйч мэргэжилтэй улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлийн хууль эрх зүйн мэдлэг олгох анхан шатны сургалтанд тус хэлтсийн Баянзүрх, Бүрэнтогтох, Хатгал, Цагаан-Үүр, Цэцэрлэг зэрэг 5 сумын улсын бүртгэгчид амжилттай хамрагдаж, тестийн шалгалтыг өгсөн.

Төрийн албаны ерөнхий шалгалт 2021 онд 2 удаа зохион байгуулагдаж тус шалгалтанд Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагч төрийн албаны ерөнхий шалгалт өгөх иргэдийн хурууны хээ тулган амйгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран ажилласан.

Хөвсгөл аймаг нь 2021 оныг Иргэдээ сонсох жил болгон зарласантай холбогдуулан Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг аймгийн ЗДТГ-т хүргүүлж, мэдээллийг нэгтгэн иргэдэд хүргэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад зориулсан улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилттэй холбоотой сургалтыг 2021 оны 08 дугаар сарын 20,21-ний өдрүүдэд хэлтсийн зүгээс амжилттай зохион байгуулж, тус хэлтсийн 36 албан хаагч амжилттай хамрагдаж, багц хууль, холбогдох дүрэм журам, улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын цахим системийн талаар мэдээлэл авсан.

Монгол улсын ерөнхийлөгчийн зарлигаар “Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласантай холбогдуулан тус хэлтсийн хамт олон 10 дугаар сарын 16-ны өдөр аймгийн “Нэг үе сааданд” 20 ширхэг хайлаас, 88 ширхэг голт бор нийт 108 ширхэг мод тарьлаа.

Монгол улсын засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан хяналт, шалгалтад тус хэлтсийн хүний нөөц хариуцсан ажилтан хуваарийн дагуу хамрагдаж, Хангалттай үнэлгээ авсан.

Урсгал засварын зардал болох 4.098.200 төгрөгийн санхүүжилтын эрхийг тавиулан, хэлтсийн барилгын дээврийн засварыг албан хаагчдын дотоод нөөцөөрөө хийж гүйцэтгэсэн.

Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, албан хаагчдын дүрэмт хувцсыг шинэчлэхэд хэлтсийн зүгээс дэмжлэг үзүүлж, байгууллагын хуримтлалын сангаас 1.229.500 төгрөг гарган, зангиа цамц, подволк авч аалбан хаагчдын хувцсыг жигдрүүлээ.

Аймгийн статистикийн хэлтэстэй хамтран аж ахуй нэгжийн улсын тооллогын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, тооллогын амжилттай зохион байгуулж ажилласан.

Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо ТББ-тай хамтран “Хариуцлагатай шилжилт” дэд төслийн хүрээнд бичиг баримтын зөрчилтэй 5 сумын иргэдийг бичиг баримтжуулж байгаа ба одоогийн байдлаар 113 иргэнийг бичиг баримтжуулж байна.

3. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэний улсын бүртгэлийн тасаг нь 2021 оны эхний хагас жилд Монгол улсын Үндсэн хууль, Улсын Бүртгэлийн Ерөнхий хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх мэдээлэх журам болон холбогдон гарсан бусад дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтлан ажиллалаа. Бүртгэлийн байгууллагын эрхэм зорилгын хүрээнд аймгийн нийт сумдад анхан шатны бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

2021 оны 11-р сарын 27 ны байдлаар Төрсний бүртгэл 2472 үүнээс эрэгтэй 1281, эмэгтэй 1191, гэрлэсний бүртгэл 777 үүнээс анхны гэрлэлт 702, дахин гэрлэлт 74, гэрлэлт сэргээсний бүртгэл 1, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 127, үүнээс захиргааны журмаар 30, шүүхийн журмаар 97, үрчилсний бүртгэл 63, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 130, ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл 78, нас барсны бүртгэл 771 бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 14, шүүхийн шийдвэрээр 3 иргэний регистрийн дугаарыг өөрчилж, иргэнийн улсын бүртгэлийн мэдээллийн санд ХААТР-15 нь тусгагдаагүй гэрлэсний бүртгэл 21, төрсний бүртгэлд эцэг болон эхийн мэдээлэл нь бүртгэгдээгүй 185 иргэний бүртгэлийг ИБАрхиваас хуулбарлан ИУБГазарт хүргүүлэн зөрчил арилгаж ажилласан байна.

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн чиглэлээр:

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25-р зүйлд заасны дагуу 2021 оны 04 сарын 09 ний өдрөөс эхлэн иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоож, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 сарын 11 ний өдрийн А/344 тушаалаар иргэний шилжилт хөдөлгөөнийг 2021 оны 6 дугаар сарын 12 ны өдрөөс сэргээж 2021 оны 11 сарын 27 ны байдлаар Бусад аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 702 бүртгэл үүнээс насанд хүрсэн 438, хүүхэд /16-аас доош насны/ 264, Сум хооронд шилжин ирсэн 1337 бүртгэл үүнээс насанд хүрсэн 833, хүүхэд /16-аас доош насны/ 504, Баг хооронд шилжин ирсэн 2098 бүртгэл үүнээс насанд хүрсэн 1238, хүүхэд /16-аас доош насны/ 860 иргэний бүртгэл хийгдэж цахим мэдээллийн санд баталгаажсан байна.

Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл буюу Иргэний үнэмлэх олголт:

Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл буюу цахим үнэмлэх олголтын 6098 бүртгэл үүнээс шинэ 1723, хаяж үрэгдүүлсэн 1254, хорин таван насны сунгалт хийлгэсэн 1551, Дөчин таван насны сунгалт 1570 бүртгэл хийгдэж сумын Улсын бүртгэгч нараас ирүүлсэн ИШБүртгэлд хамрагдсан иргэдийн мэдээлэл бүхий 498 DVD хүлээн авч цахим мэдээллийн сад тусган 4844 иргэний цахим үнэмлэхний зураг засч сүлжээнд оруулан хэвлүүлсэн байна.

Хурууны хээ давхардсан, нэрийн толинд нэр баталгаажуулаагүй, ургийн овог, эцэг, эхийн нэр өөрийн нэр зөрүүтэй 202 иргэний мэдээллийг ИУБГ-т хүргүүлэн зөрчил арилгаж иргэний цахим үнэмлэх хэвлүүлэн ажилласан байна.

Шинээр иргэний үнэмлэх авах насад хүрсэн мөн 25 ба 45 насны сунгалт хийлгэх насад хүрсэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэлд хамрагдах боломжгүй иргэдийг тухайн байгаа газарт нь очиж ИШБүртгэлд хамруулан бичиг баримтжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн хүрээнд:

Ковид-19 вирусын халдварын эрсдэл өндөр ,тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан Үндэсний энгийн гадаад паспорт захиалан авах иргэдийн тоо эрс багассан ба Үндэсний энгийн гадаад паспорт захиалах ажлын хүрээнд нийт шинээр 501 иргэний гадаад паспортын захиалга авч УБЕГ газарт хүргүүлсэн бөгөөд орчмын нутаг дэвсгэрт хялбарчилсан журмаар зорчих үнэмлэх олгох буюу ОХУ-ын хавсралтын олголт огт хийгдээгүй байна.

Иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж УБЕГ-с үндэсний энгийн гадаад паспорт, иргэний цахим үнэмлэх хэвлэгдэн ирсэн тухай мэдээллийг түргэн шуурхай хүргэж “Иргэн Таны Цахим үнэмлэх /Үндэсний энгийн гадаад паспорт/ хэвлэгдэн ирсэн байна” гэсэн мессеж явуулж хэвсгэсэн байна.

Иргэний баримтын архивын ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд тус хэлтсийн иргэний баримтын архивын лавлагаа, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн “Нээлттэй” мэдээллийг иргэдэд 6978, хууль хяналтын байгууллага болон бусад байгууллагад 704, албан хэрэгцээнд 1200 лавлагааг олгож Иргэний баримтын архивт иргэний улсын бүртгэлийн 13165 ИУБ маягтуудын баяжилт хийж хураасан бөгөөд үүнд Төрсний бүртгэл /ИУБ-11/ 2472, Үрчилсний бүртгэл /ИУБ-12/ 63, Ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл /ИУБ-13/ 78, Эцэг тогтоосны бүртгэл /ИУБ-14/ 130, Гэрлэсний бүртгэл /ИУБ-15/ 777, Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл /ИУБ-16/ 127, Нас барсны бүртгэл /ИУБ-18/ 771, Биеийн давхцахгүй өгөгдөлийн бүртгэл /ИУБ-31/ 4844, бусад аймаг хотод бүртгэл хийлгэсэн 393 маяг иргэний баримтын архивт баяжилт хийсэн байна.

Иргэний улсын бүртгэл хөтлөх журмын 22.5 д заасны дагуу Иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхээр хууль тогтоомжид заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг 24 сумын улсын бүртгэгчээс татан авч хадгаламжийн нэгж үүсгэн архивт байршуулсан бөгөөд 2020 оны бүртгэлийн дэвтэр 41ш, бүртгэлтэй холбоотой 101ш бүрдүүлбэр хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн архивт байршуулсан.

Бусад аймаг, хотод бүртгэл хийлгэсэн 393 иргэний холбогдох маягтыг тус бүр хувийн хэрэгт хавсаргасан. Мөн түүнчлэн бусад аймаг хотоос албан бичгийн дагуу ирсэн 781 иргэний холбогдох ХААТР, ИУБ маягтуудыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулсан.

Хяналтын улсын байцаагч болон тасгийн дарга, улсын бүртгэгчидэд архиваас түр ашиглахаар 176 иргэний хувийн хэргийг авахаар захиалсан бөгөөд хүлээлгэн өгч буцаан авсан байна.

Иргэний бүртгэлийн мэдээллийн санд тухайн иргэний болон эцэг, эхийн мэдээлэл зөрсөн болон зөрчилтэй 218 иргэний ХААТР, ИУБ маягт, холбогдох бүртгэлийн дэвтрийн хуулбарыг мөн тухайн бүртгэлтэй холбоотой дэвтэр шүүж зөрчил арилгуулахаар улсын бүртгэгч Б.Дуламсүрэнд хүлээлгэн өгч зөрчил арилган ажилласан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Архивын ерөнхий газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/1437, А/110 дугаар хамтарсан тушаалын хавсралт, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 11/622 чиглэл зөвлөмжийг үндэслэн тус хэлтсийн БББНШК-ын 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийн дагуу хадгалах хугацаа нь дууссан 202 нэр төрлийн хадгаламжийн нэгж, баримтыг комиссын гишүүд Мөрөн сумын 13-р багт байрлах хогийн цэгт аваачиж шатааж устгасан.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн архивын газраас ирүүлсэн 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10/6301 тоот албан бичгийн дагуу хадгалах хугацаа нь дууссан устгах баримт бичгийн судалгааг гарган хүргүүлсэн.

Мөрөн сумын 1997-2002 оны тодорхойгүй төлөвтэй, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй иргэдийн ХААТР-11 маягтыг Иргэний бүртгэлийн мэдээллийн санд шалгаж нийслэлрүү шилжин явсан 159 иргэний ХААТР маягтыг улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлж мөн бусад аймаг, хотруу шилжин явсан 81 иргэний холбогдох хувийн хэргийг аймгуудийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүллээ. 273 иргэний ХААТР-11 маягтыг галигын дагуу хувийн хэрэгт баяжилт хийж, нас барсан 19 иргэний хаатр маягтыг баяжилт хийж ажиллалаа.

Тус хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу иргэний баримтын архивын хувийн хэргийн тооллогын бэлтгэл ажлыг ханган өргөн 50см өндөр 2м, урт 2.80м-ийн 2ш төмөр тавиур шийдүүлсэн. Мөн иргэний баримтын архивт хадгалагдаж байсан хуулийн этгээдийн архивын хадгаламжийн нэгжийг зөөж туст нь архив үүсгэн хадгалаж иргэний баримтын архивыг чөлөөлж тооллого явуулах нөхцөл бололцоог бүрдүүсэн байна.

Иргэний баримтын архивын хувийн хэргийн тооллогын ажил эрчимжүүлэх зорилгоор сумдын ЗДТГазарт албан бичиг хүргүүлэн Улсын бүртгэгч нарыг хувиарын дагуу Иргэний баримтын архивын тооллогын ажилд татан оролцуулсан бөгөөд 1988-2021 оны нас барсны санд хадгалагдаж байгаа хувийн хэргийг галиглаж, шивж дууссан ба нийт 30151 иргэний 88197 ХААТР, ИУБ маягтын мэдээллийг DVD-нд хуулж хадгаламжийн нэгж үүсгэн хадгалсан.

Хүүхдийн хувийн хэргийн санд хадгалагдаж байгаа ИУБ маягтуудыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шалгаж шилжин явсан хүүхдийн хувийн хэргийг харъяа аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж, нас

барсан болон насанд хүрсэн иргэдийн хувийн хэргийг цэгцлэн нийт 44613 хүүхдийн ХААТР, ИУБ маягтыг тоолж, шивж мэдээллийг DVD-нд хуулж хадгаламжийн нэгж үүсгэн хадгалсан.

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Алаг-Эрдэнэ, Арбулаг, Баянзүрх, Бүрэнтогтох, Галт, Жаргалант, Их-Уул, Мөрөн, Рашаант, Рэнчинлүмбэ, Тариалан, Тосонцэнгэл, Төмөрбулаг, Түнэл, Улаан-Уул, Ханх, Цагаан-Үүр, Цагаан-Уул, Цагааннуур, Цэцэрлэг, Чандмань-өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сумдын ИТХ-н тогтоол хуулийн хугацаандаа Улсын бүртгэлийн хэлтэст бүрэн ирүүлсэн байна. ИТХ-ын тогтоолын дагуу санал авах байр буюу түүнд хамаарах хаягийн мэдээлэл хэсгийн төвийг Иргэний улсын бүртгэлийн системд бүрэн шивж дууссан ба алдаатай болон дутуу мэдээллийг нягтлан шалгаж ажиллалаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг 2021 оны 04 сарын 09 ний өдрөөс сонгуулийн дүнг нийтэд мэдээлсний дараах өдөр хүртэл түр зогсоож 23 сумын шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрийг хааж үлдэгдэл ИУБ-22 маягтын хамт татан авч лацдан иргэний баримтын архивт хадгалаж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 сарын 11 ний өдрийн А/344 Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээх тухай тушаалыг үндэслэн бүртгэлийн дэвтэр, үнэт цаасыг буцаан хүлээлгэн өгч ажиллалаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Хөвсгөл аймгийн 129 хэсгийн санал авах байрны дэргэд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын 130 итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргаж Аймгийн тагнуулын хэлтэст хүргүүлэн тус хэлтсийн саналыг үндэслэн 130 итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулан авсан болно.

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил, сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалтыг 2021 оны 05 сарын 11-12 ны өдрүүдэд онлайн хэлбэрээр Хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг Иргэний улсын бүртгэлтйн тасгийн дарга, Улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, Тагнуулын хэлтсийн ажилтан Г.Түмэнжаргал нар удирдан зохион байгуулж Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулан ажиллалаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 зүйлд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, танилцуулах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу чанартай хийж гүйцэтгэж УБЕГ-аас эрх олгосон улсын бүртгэгч нар СНЖ-г хэвлэж санал хураахаас 25 аас доошгүй хоногийн өмнө сумдын сонгуулийн хороодод хүлээлгэн өгч, Сумын сонгуулийн хорооны гишүүд болон итгэмжлэгдсэн ажилтнуудад “Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам”-ын талаар харилцан мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулсан байна.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС


Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны 129 хэсгийн хороонд ажиллах 130 итгэмжлэгдсэн ажилтанд зориулсан сонгуулийн ирц бүртгэлийн програмын дадлага олгох, эрх зүйн сургалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн газрын дарга Т.Төгөлдөрөөр ахлуулсан, Баянзүрх дүүргийн Хяналтын улсын байцаагч Д.Оюунтүлхүүр, Мэдээлэл технологийн газрын ахлах мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, гэрээт ажилтан Т.Баасансүрэн нар удирдан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн 2021 оны 05 сарын 30-31 ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тус сургалтын явцад сургалтын багийн гишүүд, Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагч Б.Мөнгөнзул, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, Хөвсгөл аймаг дахь тагнуулын газрын ажилтан Г.Түмэнжаргал нарыг байлцуулан сонгогч шилжилт хөдөлгөөн, түр хасав төлөв сэргээсэн, Иргэний бүртгэлтэй холбоотой 1450 Лавлагааг тусгаж СНЖ-ыг эцсийн байлаар хэвлэж ирц бүртгэлийн программыг акт үйлдэн түгжин, лацдаж цагдаагийн хамгаалалтан доор Хөвсгөл аймаг дахь тагнуулын газарт хүлээлгэн өгсөн болно.




Хөвсгөл аймгийн сонгуулийн 129 хэсгийн хороонд тоног төхөөрөмж, сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлгэн өгөх ажлыг 2021 оны 06 сарын 02-03 ний өдөр зохион байгуулж Хөвсгөл аймаг дахь тагнуулын газраас тухайн сумын сонгуулийн хорооны дарга, хэсэг тус бүрийн ахлах зохион байгуулагч, Итгэмжлэгдсэн ажилтан, Цагдаагийн албан хаагч нарыг байцуулан акт үйлдэж, гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажиллалаа.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Улсын бүртгэлийн хэлтсийн хийж хэрэгжүүлэх ажлын дэд төлөвлөгөөнд туссан ажлууд 100 хувь хийгдэж Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийг амжилттай зохион байгуулж, ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийг УБЕГазарт хүлээлгэн өгч ажиллалаа.

Иргэний улсын бүртгэлийн сүүлийн 3 жилийн эхний хагас жилийн судалгааг графикаар харуулав:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



4. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Улсын тэмдэгтийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол улсын засгийн газрын 2020.12.23-ны өдрийн 230 дугаар тогтоол, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх үл хөдлөх хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулж иргэнийг эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэх бүрэн боломжоор хангах зорилт тавин ажиллаж нийт **14436** мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг хөтлөн ажиллалаа.

Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг тухай бүр зохион байгуулж ажилласан байна.

Иргэдээс “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.7-д заасан шалтгаанаар хувийн хэрэг хаалгахаар ирүүлсэн хүсэлт холбогдох баримт бичиг, мэдүүлгийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 23, газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 2 хувийн хэрэг бүртгэлийг улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар тус тус хаасан байна.


Мөн иргэн хуулийн этгээдээс үрэгдүүлсэн гэрчилгээг дахин авах тухай өргөдөл хүсэлт, нотлох баримтыг үндэслэн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцуулж үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 14, газар өмчлөх эрхийн 4 гэрчилгээг дахин олгож ажиллалаа.

Нэг. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх


Газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлийн үйчилгээг иргэдэд хуулийн хугацаанд түргэн шуурхай үзүүлж газар өмчлөх эрхийн бүртгэл нийт **499**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл **1008**-ийг бүртгэж нийт **1507** шинэ хувийн хэрэг үүсгэн архивт байрлуулсан байна.



Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:



Газар өмчлөх эрхийг анх удаа бүртгэх бүртгэлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:




Хоёр. Барьцааны бүртгэл /ипотек/

Тайлант хугацаанд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны бүртгэлийн **6993** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн ба үүнээс барьцаалбартай барьцааны гэрээ **2362**, барьцаалбаргүй барьцааны гэрээ **1324**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **263**, барьцааны гэрээ дуусгавар болгох **3044** -ийг тус тус хүлээн авч бүртгэсэн. Мөн газар өмчлөх эрхийн барьцааны бүртгэлийн **3792** мэдүүлэг хүлээн авсан ба үүнээс барьцаалбаргүй барьцааны гэрээ **1990**, барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах **90**, барьцааны гэрээ дуусгавар болгох **1712** -ийг тус тус хүлээн авч бүртгэсэн. 2021 онд барьцааны бүртгэл харьцангуй ихэссэн нь Засгийн газраас олгосон бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл буюу 3 хувийн зээлд иргэд аж ахуй нэгж байгууллага их хамрагдсантай холбоотой юм.




Гурав. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх

2021 онд үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл 925, газар өмчлөх эрхийн гэрээний бүртгэл 655 нийт **1580** мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн байна. Үүнээс бэлэглэлийн гэрээгээр 163, ХХАГ-ээр 1067, арилжааны гэрээгээр 4, өв залгамжлах эрхийн бүртгэл 170, хамтран өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлээр 169, бусад гэрээ хэлцлээр 7 бүртгэл тус тус бүртгэсэн байна.




Дөрөв. Эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэмэлт өөрчлөлт оруулах **462** мэдүүлэг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн байна. Үүнээс эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх – **270**, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх -**20**, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх-**156**, эд хөрөнгийн үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх-**16**-г тус тус бүртгэж, холбогдох материалыг архивт хүлээлгэн өгч ажиллалаа.



Тав. Лавлагаа хуулбар олголт:

Тайлант хугацаанд газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн нийт 321 лавлагаа, хуулбар 8 тус тус олгосон байна.



Зургаа. Газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл:

Аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумын газрын даамлын газар эзэмших ашиглах эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр дундын мэдээллийн санд оруулсан мэдээллийг нягтлан шалгаж 2053 эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаарыг олгон ажиллалаа



Долоо . Архив, мэдээллийн сан, үйлчилгээний хураамжийн талаар:

Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд байнгын хяналт тавин ажиллаж, галын аюулгүй байдлын самбар, галын буланг шинэчлэн байрлуулсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив нь өдөр тутамдаа хувийн хэргийн баяжилт хийгддэг хөдөлгөөнт архив учраас архивын тавиур дүүрч УБЕГ-ын нэгдсэн архивын газраас 5 ширхэг төмөр рамтай тавиур авчран архивт байрлуулан өдөр тутмын баяжилтаа хийж байна.

2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн архивт үл хөдлөх эд хөрөнгийн 17150, газар өмчлөх эрхийн 12399, газар эзэмших эрхийн 6915 нийт 36464 хувийн хэрэг байрлаж байна.


Тайлант хугацаанд 12929 хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд тус үйлчилгээгээр 157 162 039 / нэг зуун тавин долоон сая нэг зуун жаран хоёр мянга гучин ес / төгрөгийн мөнгөн орлогыг төвлөрүүлсэн ба үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ худалдан борлуулсны 2 хувь 251 542 108 / хоёр зуун тавин нэгэн сая таван зуун дөчин хоёр мянга, нэг зуун найм / төгрөгийг татварын орлогод төвлөрүүлсэн байна. Шинээр 1508 хувийн хэрэг нээж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэлийг архивт хүлээн авч архивт байрлуулсан. Үл хөдлөх эд хөрөнгө анх удаа бүртгүүлсний тэмдэгтийн хураамжинд 39 237 233 /гучин есөн сая хоёр зуун гучин долоон мянга хоёр зуун гучин гурав/ төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС


Хөрөнгөгүй лавлагааг 250 нэгж үүсгэн багцалж үдэн архивын санд байршуулсан болно.

Тус тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив нь сэлбэн засах шаардлагатай хувийн хэрэг баримтыг нөхөн сэргээх, сэлбэн засах ажлыг өдөр тутмын үйл ажиллагаагаараа тогтмол хийж хэвшсэн.

2021 оны 01 дүгээр сард архивын хувийн хэргийн ангилан ялгасан хуудасны тооллогыг хийж тусгаарласан хуудасны судалгааг гаргаж ЭХЭУБГазарт хүргүүлсэн.



2021 онд үйлчилгээний хураамжийн дүн эрс буурсан нь Засгийн газраас үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн баталсантай холбоотой юм.



Найм. Өргөдөл гомдол, мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаарх тоон мэдээг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон эд хөрөнгийн бүртгэл, цахимжуулалтын газарт хүргүүлж ажиллалаа.

Улсын бүртгэгч нар гэрчилгээ болон үнэт цаасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж тайланг ахлах нягтлан бодогчоор хянуулж тооцоо нийлж ажиллаж хэвшсэн болно.

Хөвсгөл аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газраас ирүүлсэн 136 албан бичгийн хариу лавлагаа мэдээллийг хугацаанд хүргүүлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн албан бичиг тогтоол шийдвэрийн дагуу 63 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, 41 эрхийн улсын бүртгэлийн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт газар эзэмших ашиглах эрхийн Э дугаар, ePRS програм дахь Г дугаарын давхардлын судалгааг гарган хүргүүлсэн мөн цахим мэдээллийн санд оруулсан засвар өөрчлөлтийн тайланг 2 удаа тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллалаа.

2021 оны нэгдүгээр сард Аймгийн ЗДТГазарт иргэн хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө өмчилсөн эсэх судалгааг гаргаж хүргүүлсэн. Шинээр баригдсан ба жагсаалтаар салж бүртгэгдсэн орон сууцны дэлгэрэнгүй судалгааг дэлгэрэнгүй гаргаж ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

Ес. Мэдээлэл сургалт, сурталчилгаа

Аймгийн ГХБХБГазар, ШШГГазар, тойргийн нотариатууд, Татварын хэлтэс, Сумдын тамгын газрын дарга нартай тогтмол мэдээлэл солилцож хамтран ажиллалаа.

2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагын төлөөллийг оролцуулан Засгийн газраас олгож буй 3%-ийн хөнгөлөлттэй зээл, “Ковид”-ийн хол хориотой үед иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх талаар уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтанд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, хяналтын байцаагч, эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч, ерөнхий нягтлан бодогч нар оролцож чиглэл тус бүрээр хамтран ажиллахаар санал солилцов.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний самбарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл тус бүрийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, үйлчилгээний хураамж болон тэмдэгтийн хураамжийн мэдээллийг байршуулсан. Монгол улсын засгийн газрын 2020.12.23-ны өдрийн тогтоолоор Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 2021.07.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан үйлчилгээний самбарын мэдээллийг шинэчлэн ажилласан.

Мөн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны ил тод байдлын мэдээллийн самбарт сар бүрийн тоон мэдээг байршуулж байна.

Иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл тус бүрийн материалын бүрдүүлбэр, маршрутыг агуулсан боршур, гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, мэдээ мэдээлээр ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хамт олон дараах мэдээлэл, сургалтанд хамрагдсан байна.

УБЕГ-ын БТДШГ-аас зохион байгуулсан “Байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд ” сэдэвт онлайн сургалтанд хамрагдлаа.

2021.01.08-ны өдөр Аймгийн засаг даргын тамгын газрын Соёмбо танхимд зохион байгуулсан ЗГХЭГ-ын “Стратеги төлөвлөгөө гаргах, батлах, тайлагнах журам” сэдэвт онлайн сургалтанд хамрагдсан.

УБЕГ-ын ЭХЭУБГазраас 2021.03.17, 2021.06.07-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсан онлайн сургалтанд хамрагдсан.

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Барут/Марк хотоос Мөрөн хотод хэрэгжиж уй KCS-058- BARUTH/MARK-2020 төслийн хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах “КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, тандах, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах нь” сэдэвт сургалтанд хамрагдсан.

2021.05.30-ны өдрөөс 2021.05.31-ний өдөр Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтны тоног төхөөрөмжийн болон эрх зүйн сургалтанд хамрагдлаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан цахим сургалтанд тасгийн албан хаагчид тухай бүр бүрэн хамрагдлаа.

2021 оны 08 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан бүсчилсэн сургалтанд тасгийн улсын бүртгэгч, архивч нар бүрэн хамрагдсан.

Арав. Бусад зохион байгуулсан ажлууд

Цахим сан дахь 206 бүртгэлийн нотлох баримтыг архивын эх баримттай тулган шалгаж цахимжуулалтын явцад буруу цахимжуулсан, бүртгэлийн явцад буруу дутуу боловсруулсан 228 алдаа зөрчлийг жагсаалтаар гаргаж хяналтын улсын байцаагчид дүгнэлт гаргуулахаар хүргүүлээ.

Цахим сан дахь алдаатай 69 бүртгэлийн 107 зөрчилтэй мэдээлэл нотлох баримтанд хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэн засвар өөрчлөлт оруулж залрууллаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цаасан баримтыг цахимжуулах явцад эрхийн улсын бүртгэлийн дугаар нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2008.11.14-ний өдрийн тушаалаар сумын эрхийн улсын бүртгэлийн код нь залруулагдаагүй орхигдсоны улмаас цахимжуулах боломжгүй үлдсэн 15 хувийн хэргийг хяналтын улсын байцаагчаар дүгнэлтийг үндэслэн шинээр эрхийн улсын бүртгэлийн дугаар авч цахимжуулж EPRS2 системд орууллаа.

Мөрөн, Түнэл сумын хилийн цэс зөрчин олгогдсон иргэдийн нэр дээрх өмчлөх эрхийг хаяг болон регистрийн дугаараар нь мэдээллийн санд шүүж газар өмчлөх эрхийн 204, үл хөдлөх эд хөрөнгийн 79 бүртгэлийн судалгааг гаргаж, хяналтын улсын байцаагчаар гаргуулан, иргэдийг хүсэлтийн дагуу 76 иргэний өмчлөх эрхийн гэрчилгээний улсын бүртгэлийн дугаар болон хаягийг сольж олгосон байна.

5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэл нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам, Иргэн, хуулийн этгээдийн тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам болон бусад холбогдох хууль, журам, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, чиглэл, журмын хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт 1153 иргэн хуулийн этгээдийн материал хүлээн авч ажилласан байна.

1. Хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах бүртгэл:

Шинээр 159 хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулан, шинээр үүсгэн байгуулагдсан 159 хуулийн этгээдийн материалыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэж хувийн хэрэг нээн архивт хүлээлгэн өглөө. Үүнд:

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани 123,
- Хоршоо 9,
- Төрийн бус байгууллага 22,
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 3
- Төрийн байгууллага албан байгууллага 1
- Сан 1-ыг газрыг тус тус бүртгэж хувийн хэрэг үүсгэж цахимжуулан архивт хүлээлгэн өгсөн байна.

2. Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өөрчлөлт 410-г хүлээн авснаас

- Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээгээ гээгдүүлсэн буюу гэмтээсэн бусад шалтгаанаар 67,
- Хуулийн этгээдийн эрх шилжүүлэх болон өв залгамжлагчаар үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн , хаяг, дүрмийн сан, гишүүн нэмэх хасах бусад шалтгаанаар бүртгэлийн мэдээлэлдээ өөрчлөлт оруулсан 318,
- татан буугдсан 25-н хуулийн этгээдийн холбогдох материалыг хүлээн авч бүртгэн хувийн хэрэгт баяжилт хийн цахимжуулан архивт хуулийн хугацаанд хүлээлгэн өглөө.

3. Иргэн хуулийн этгээдийн лавлагаа, хуулбар

Хуулийн этгээдийн лавлагаа

- Иргэн, хуулийн этгээдийн лавлагаа 112,
- Төрийн байгууллагад лавлагаа 18 нийт 130 лавлагаа олгосон байна.

Хуулийн этгээдийн хувийн хэргээс хуулбар

- Иргэн, хуулийн этгээдэд хуулбар 19,
- Төрийн байгууллагад хуулбар 12 нийт 31 хуулбар олгосон байна.

4. Архив, мэдээллийн сан

2021.11.25 байдлаар хуулийн этгээдийн архивт цахим санд бүртгэлтэй 2573 , татан буугдсан 295 шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 нийт 3003 хуулийн этгээдийн хувийн хэрэг байршиж байна.

Шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 135 хуулийн этгээд.

№	Хэлбэр	Тоо
1	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	31
2	Төрийн бус байгууллага	33
3	Хоршоо	2
4	Сан	4
5	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	24
6	Бүрэн бус хариуцлагатай компани	12
7	Шашны байгууллага	7
8	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	18
9	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	1
10	Хувиараа эрхлэх аж ахуй	1
11	Нөхөрлөл	2

Цахим санд бүртгэлтэй 2868 хуулийн этгээд.

№	Хэлбэр	Тоо
1	Хувьцаат компани	12
2	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	1545
3	Төрийн өмчит хувьцаат компани	1
4	Орон нутгийн өмчит хувьцаат компани	1
5	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	2
6	Бүх гишүүд бүрэн хариуцлагатай нөхөрлөл	77
7	Боловсрол сургалтын байгууллага	1
8	Төрийн бус байгууллага байгууллага	295
9	Хоршоо	292
10	Хадгаламж зээлийн хоршоо	7
11	Сан	12
12	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	3
13	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	53
14	Шашны байгууллага	25
15	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	14
16	Банк бус санхүүгийн байгууллага	3
17	Татан буугдсан	295

5. Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох

Иргэн хуулийн этгээдийн тамга, тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу 200-н хуулийн этгээдийн болон хуулийн этгээдийн эрхгүй этгээдэд тэмдэг, баталгааны тэмдэгийн хяналтын дугаарыг олгож 2021 оны 11 сарын 25-ны байдлаар татан буугдсан, хэлбэр ашиглалтын шаардлага хангахгүй болон бусад шалтгаанаар хураагдсан 65 ширхэг хуулийн этгээдийн тамга тэмдэг, баталгааны тэмдгийг хадгалалт хамгаалалтын шаардлага хангасан сейф шүүгэнд хадгалж хуулийн хугацаанд нь устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

6. Мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт

Сар бүрийн 25-наар тасалбар болгон хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны тайлан, орлогын мэдээ, архивын орлогын мэдээг батлагдсан маягтын дагуу хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж холбогдох албан тушаалтанд цахимаар болон цаасаар хүргүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хариутай албан бичгийг тогтоосон хугацаанд холбогдох мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна. Энэ оны байдлаар шинэчисэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа, улсын бүртгэлд бүртгэлтэй шашны байгууллагын судалгааг тус тус хүргүүлсэн байна.

Хууль хяналтын болон төрийн байгууллагаас ирүүлсэн 30 хугацаатай албан бичигт хуулийн хугацаанд хариу өгч холбогдох материалыг хувийн хэрэгт хавсарган архивт хүлээлгэн өгч ажиллаа.

7. Орон нутгийн болон бүртгэлийн хэлтсийн дансанд төвлөрүүлсэн үйлчилгээний хураамж

Орон нутгийн дансанд шинээр үүсгэн байгуулагдсан болон хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт, лавлагааны үйлчилгээний хураамж болох 14250000 / арван дөрвөн сая хоёр зуун тавин мянга /-н төгрөг, улсын бүртгэлийн дансанд хуулбар, нэрийн баталгаажуулалт, тамга тэмдэгийн хяналтын хуудсаны үйлчилгээний хураамж 1493000 /нэг сая дөрвөн зуун ерэн гурван мянга /-н төгрөг, нийт 15.743.000 / арван таван сая долоон зуун дөчин гурван мянга/-н төвлөрүүлэн ажилласан байна.

8. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх ажил

2021 оны 01 дүгээр сарын 11-нд “Түмний телевиз”-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлтийн талаар болон цаг үеийн байдлын талаарх мэдээлэл өгөв.

Мөрөн суманд 209, бусад сумдад 66 нийт аймгийн хэмжээнд 275 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн төрийн бус байгууллагыг 23-н сумаар нь ялган excel файл үүсгэн сумдын улсын бүртгэгч нарт албан бичиг, тайлан ирүүлэх загвар хүснэгт, мөн тухайн сумдад үйл ажиллагаа явуулж байгаа 66 төрийн бус байгууллагын мэдээллийг хүргүүлэн ажилласан. Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа 209 төрийн бус байгууллагын үүсгэн байгуулагч нарт тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар утсаар зөвөлгөө өгч Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн faje хуудас, Хөвсгөл аймгийн хэмжээний төрийн бус байгууллагын нэгдсэн face групп / Хөвсгөл ТББ /-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэх тухай мэдээлэл, тайлангын загвар маягтыг тус тус байршуулан, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайлан ирүүлэх хуулийн хугацаанд 58 төрийн бус байгууллагын тайланг хүлээн авч нэгтгэн архивт хүлээлгэн өглөө.

2021 оны 3 дугаар сарын 26-нд 22 сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн бүртгэлийн цаг үеийн мэдээ мэдээллийн чиглэлээр болон шинээр батлагдсан маягт, 2021 оны 07 сарын 01-нд хэрэгжих эхлэх тэмдэгтийн хураамжийн тухай хууль, суманд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг ямар байдлаар иргэдэд үзүүлбэл зохистой талаарх судалгаа санал асуулга авч цахимаар мэдээлэл өгөв.

2021 оны 04 дүгээр сарын 19-нд “Хөвсгөл телевиз”-д Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан 2021 оны 07 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон тухай мэдээлэл өгөв.

2021 оны 05 дугаар сарын 18-нд Хөвсгөл аймгийн Их-Уул, Тариалан, Эрдэнэбулган суманд төрийн байгууллагын албан хаагчидад иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгөв.

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулахын тулд утсаар давхардсан тоогоор 1000 орчим иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч, оноосон нэрийн хүсэлтийг утсаар авч шүүн 200 гаруй msg-д хариу илгээж, хуулийн этгээд шинээр байгуулах, нэмэлт өөрчлөлт бүртгүүлэхтэй холбоотой загвар маягыг сумдын улсын бүртгэгчээр дамжуулан иргэдэд хүргүүлж хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй авах нөхцөл боломжоор ханган, зарим тохиолдолд үйлчилгээнд ашиглагдаж байгаа загвар маягтуудыг цахим шуудангаар илгээн ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журмуудын шинэлэг зохицуулалтын талаарх мэдээлэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас гаргасан дүрсжүүлсэн гарын авлага мэдээллийг байгууллагын байранд байрлах дэлгэцээр гаргаж иргэдэд мэдээлэл түгээж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд түгээх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг бүхий мэдээллийн самбарыг байгууллагын байрны үйлчилгээний зааланд байршуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т заасан нээлттэй мэдээллийг хэрхэн танилцах, хуулийн этгээдийн лавлагаа, хуулийн этгээдтэй эсэх талаарх лавлагааг хэрхэн цахимаар авах талаар мэдээллийг иргэдэд цахимаар түгээн ажиллаж байна.

Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан khuvsgul.burtgel.gov.mn, Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтэс Faje хуудас, E-Mongolia-наас шаардлагатай мэдээлэл, лавлагаагаа авах боломжтой тухай, улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэлтэй хэрхэн танилцах зэрэг зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цаашид ямар байдлаар сайжруулах саналтай байна вэ? гэсэн асуултанд иргэд дараах байдлаар санал ирүүлсэн байна.

1. Үйлчилгээний хураамжийг цахим байдлаар тушаадаг болох
2. Төрийн албан хаагчдын ажлын ачааллыг буруулах тал дээр бодитой арга хэмжээ авах
3. Цахимаар авч болдог төрийн үйлчилгээнүүдийг сайн суртчилах
4. Сумандаа зарим бүртгэлийг хийдэг болох гэсэн саналуудыг ирүүлсэн байна.

2021 оны 11 дүгээр сарын 19-нд сумдын улсын бүртгэгч нарын сургалтанд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой цаг үеийн мэдээ мэдээллийг өгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн өдөр тутмын бүртгэлийн ажилаа сумдын бүртгэгч нар танилцуулж ажиллаа.

2021 оны 12 дугаар сарын 01-нд Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын удирдлагад сургалт мэдээлэл өгөв

9. Мэдлэг ур чадвараа дэшлүүлэх, сургалт

2021.02.23-онд Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газраас “Ковид-19” халдварын тухай, хэрхэн сэргийлэх, Халдварын илрэх хэлбэр, халдваргүйжүүлтийг хэрхэн яаж хийх тухай сургалтанд хамрагдаж гэрчилгээ авав.

2021.02.25-нд “21 өдрийн гайхамшиг” нэртэй сургалтанд 21 өдрийн турш цахимаар хамрагдав.

2021.04.25-нд “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний сургалтанд цахимаар хамрагдаж амжилттай төгсөн цахим гэрчилгээ авсан.

2021.05.19-нд аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сургалт

2021 оны 07 дугаар сарын 20-нд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас шинээр батлагдан гарсан загвар маягт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх журамд оруулсан өөрчлөлтийн талаар онлайн сургалт

2021.08.21-22-ны хооронд Улсын бүртгэлийн ерөнхий газраас орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад зориулсан 2 өдрийн сургалт

2021.09.02-03-ны хооронд Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсээс зохион байгуулсан Терроризмтэй тэмцэх зөвлөл, хамтын ажиллагааны зөвлөлийн 2021 оны орон нутаг дахь хамтарсан 2 өдрийн сургалт

2021 оны 09 дугаар сарын 25-нд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас шинээр батлагдан гарсан хоршооны тухай хуулийн талаар онлайн сургалт

2021.11.16-нд Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтын газраас хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, улсын бүртгэл хөтлөхөд гарч буй алдаа дутагдал, чаашид анхаарах асуудлаар онлайн сургалт

10. Төлөвлөгөөт ажил

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа 66 төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлт дээр хамтран ажиллах зорилгоор сумдын улсын бүртгэгч нарт албан бичиг, тайлан ирүүлэх загвар хүснэгт, мөн тухайн сумданд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагын мэдээллийг хүргүүлэн хуулийн хугацаанд 58 байгууллагын тайланг авсан хүлээн авсан.

Хуулийн этгээдийн архивт хадгалагдаж байгаа улаан дэвтрийн мэдээллийг цахим файл болгон хадгалах ажлыг бүрэн хийж дуусгасан.


Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ers программаар ирүүлсэн 32 чиглэл зөвлөмж хариутай албан бичиг судалгааг тогтоосон хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

11. Төрийн байгууллагын хамтын ажиллагаа


Аймгийн Татварын хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын харьяа Хөвсгөл аймаг дахь хэлтэс, Статистикийн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж шинээр бүртгэгдсэн болон татан буугдсан аж ахуй нэгжүүд, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй хуулийн этгээдийн судалгаа зэргийг улирал тутам тулган баталгаажуулан ажиллаж байна. Аж ахуй нэгжийн тооллоготой холбогдуулан суманд бүртгэлтэй хуулийн этгээдийн судалгааг сумдын улсын бүртгэгч нарт гарган хүргүүлж, аймгийн статисткийн хэлтэстэй хамтран ажиллаж шаардлагатай мэдээллээр ханган ажиллалаа.

Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан улсын бүртгэлийн www.burtgel.gov.mn www.khuvsgul.burtgel.gov.mn Хөвсгөл аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс page хуудас, E-Mongolia-аас шаардлагатай мэдээлэл, лавлагаагаа авах боломжтой тухай, улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэлтэй хэрхэн танилцах зэрэг зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллав.


2017-2021 оны байдлаар шинээр үүсгэн байгуулагдсан татан буугдсан хуулийн этгээд




2017-2021 онд хүлээн авсан материал



2017-2021 онд орон нутгийн болон улсын бүртгэлийн хэлтсийн дансанд орсон үйлчилгэний хураамж



2017-2021 онд тамга тэмдэгний хяналтын дугаар авсан болон хураагдсан тамга, тэмдэг



6. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч Б.Мөнгөнзул нь 2021 оны хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулах, улсын бүртгэлийн ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу 2021 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Бодлого зорилтыг хангах чиглэлээр:

Тайлант хугацаанд хяналт, шалгалтын ажлыг хэрэгжүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль, эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, журам, дүрэм, заавруудыг үйл ажиллагаандаа удирдлага болгон хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын үйлчилгээний стандарт, хөдөлмөрийн дотоод журмын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж иргэний улсын бүртгэлийн нийт 4171 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан ажлыг хийж гүйцэтгэсэн.

Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд нийт 3413 бүртгэлээс 129 зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан ажлын хүрээнд иргэний шилжилт хөдөлгөөн, сонгогчийн шилжилт хөдөлгөөний нийт 2841 бүртгэлд хяналт ажилласан байна.

Хяналт шалгалтын газраас 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийн хүртэлх улсын бүртгэл түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмд нийцсэн эсэхийг хянаж шалгахад илэрсэн зөрчлийг улсын байцаагчийн албан шаардлагын дагуу арилгаж ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар эд хөрөнгийн эрхийн 520 бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажиллалаа.

Хяналт тавьсан бүртгэлээс 346 зөрчил илэрч хяналтын байцаагчийн дүгнэлтээр зөрчлийг арилган ажиллалаа.

Хяналт шалгалтын газраас 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 09-ны өдрийнг хүртэлх улсын бүртгэл түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмд нийцсэн эсэхийг хянаж шалгахад илэрсэн зөрчлийг улсын байцаагчийн албан шаардлагын дагуу арилгаж ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллаж байна

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын дагуу байцаагчийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан болон өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар 113 бүртгэлийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажилласан бөгөөд хяналт шалгалтаар 17 зөрчлийг илрүүлж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр арилгасан байна.

Хуулийн этгээдийн архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрхлэн хөтөлж байгаа эсэх, түүний хадгалалт хамгаалалт, найдвартай байдлыг ханган ажиллаж байгаа эсэхэд байнгын хяналт тавин ажиллалаа.

Архивын улсын бүртгэлд чиглэлээр:

Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 125 бүртгэлд хяналт тавьж ажиллалаа. Мөн байгууллагын БНШАЗК-ын үйл ажиллагаагааг хэлтсийн 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 202 нэр төрлийн баримт бичгийг устгасан.

Хууль шүүхийн байгууллагад итгэмжлэлээр оролцох:

Хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөгчөөр оролцож хуулийн этгээдийн бүртгэлийн 1 маргааныг шийдвэрлэсэн болно.

Торгууль, шийтгэвэр:

2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 169 иргэнд торгуулийн хуудсаар 7.010.000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.


Өргөдөл гомдлын шийдвэрлэлт мэдээ тайлан, хугацаатай албан бичгийн шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 79 өргөдөл ирсэн байна.


Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар -23
- Эд хөрөнгийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар - 27
- Бусад үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 29


Хяналт шалгалтын ажлын статистик тоон мэдээг сарын бүрийн 25-наар тасалбар болгон УБЕГ-ын Хяналтын Шалгалтын газар газарт хүргүүлэн ажиллаж байна.



Хяналтын байцаагчийн гаргасан дүгнэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл



Хяналтын улсын байцаагчийн хянасан бүртгэлийг сүүлийн 3 жилийн эхний хагас жилийн байдлаар харьцуулбал:



7. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 оны жилийн эцсийн тайлан балансаа гарган 2020 оны тайлангийн аудитаар “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт авч УБЕГазарт нэгтгүүлсэн. Тайлантай холбоотой бүхий л мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь гарган өгч Аймгийн Аудитын газартай хамтран ажиллалаа.

Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой зардлын тооцоог нэг бүрчлэн гарган албан албан хаагчдын цалин НДШ-тэй холбоотой өглөг үүссэн тооцоог УБЕГазарт саналыг хүргүүлэн шийдвэрлүүлж Нийгмийн даатгалын шимтгэлийн болон цалинтай холбоотой өглөггүй ажиллалаа.

Сар бүрийн орлогын мэдээг тасгуудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн УБЕГазарт хүргүүлж байгаа бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг УБЕГазраас ирүүлсэн чиглэлийн дагуу орлогын нэр төрөл, мөнгөн хөрөнгийн данс бүрээр, өглөг авлагын задаргаа бүрээр цаг хугацаанд чанартай гарган УБЕГазарт хүргүүлэн, Шилэн дансны сайт, Хөвсгөл УБХэлтсийн мэдээллийн сайт, байгууллагын “Санхүүгийн ил тод байдлын” самбарт нээлттэйгээр байрлуулан ажиллаж байна. Мөн Шилэн дансны сайтад Улсын тэмдэгтийн хураамжийн шинэчлэгдсэн хураамж, 2020 оны аудитын дүгнэлт, Бүртгэгч нарын 2021 оны 1-9 сарын үнэт цаасны кодтой тайланг хугацаа хоцроогүй нэгтгэн УБЕГазрын санхүүд хүргүүлээд байна. Сангийн яамны сайтад 2020 оны балансыг, ТӨХ-ны сайтад 2020 оны баланс болон Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн мэдээг зохих зааврын дагуу хугацаанд нь хүргүүлсэн.

2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан балансыг зохих хууль журмын дагуу гарган УБЕГ-т хүргүүлж, хянуулан Сангийн яамны э-тайланд шивж баталгаажуулсан.



2021 онд батлагдсан 648.552.800 төгрөгийн төсвөөс 11 сарын байдлаар 623.020.300 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 270.515.568 төгрөгийн орлого оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна.

2021 оны МУ-н Ерөнхийлөгчийн сонгуулиар 116 135 400.00 төгрөгийн санхүүжилт хийгдэн, батлагдсан хуваарийн дагуу зарцуулан ажиллаж байна.

Ажиллагсдын цалингийн картыг тогтмол хөтлөн, Нийгмийн даатгалын тайланг Нийгмийн даатгалын сайтаар орж хүн нэг бүрчлэн шивж оруулж байна. Мөн татварын суутганы тайланг хүн бүрээр шивж оруулж байгаа.

Нийгмийн даатгалын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил төлбөргүй гарсан. Ажиллагсдын хамтын сангийн журмын дагуу сар бүр ажиллагсдын цалингаас суутгалыг хийн холбогдох данс руу нь шилжүүлж тооцоог хянан ажиллаж байна.

Тайлант хугацаанд Ковид өвчний хөл хорионы үе байсан хэдий ч УБЕГазраас татан авах үнэт цаас, бараа материалыг машин техник хүн хүчний боломжоороо тасралтгүй ханган байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тасалдуулалгүй ажиллаж байна. Сумдын улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг код бүрээр тулган баталгаажуулж заасан хугацаанд нь УБЕГазрын санхүүд нэгтгэн хүргүүлж байна.




8. АРХИВ, АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллалаа. Тус хэлтэс нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 1452 албан бичгийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажласан бөгөөд 781 албан бичгийг хүлээн авсан байна. Хүлээн авсан 781 албан бичгээс 550 нь хариутай албан бичиг байсан ба холбогдох хариуг цаг хугацаанд нь шийдвэрлэж хүргүүлсэн байна. Тайлант хугацаанд Хэлтсийн даргын 27 тушаалыг бүртгэж ажилласнаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 17, хүний нөөцтэй холбоотой Б тушаал 10-г тус тус гарган хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Мөн тайлант хугацаанд улсын бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс нийт 79 өргөдөл, гомдол ирсэн ба өргөдөл, гомдлыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь хуваарилан, шийдвэрлүүлж, 4 өргөдөл гомдлын шийдэвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж байна. ABLE программд нийт дотоод албан бичиг 56 ирсэн ба 231 албан бичиг явуулсан байна. Khuvsgul@burtgel.gov.mn хаягаар 551 албан бичиг ирсэн ба 425 албан бичиг явуулсан бол орон нутгийн UBurtgel@khs.gov.mn хаягаар 157 албан бичиг ирсэн, 123 албан бичиг тус тус явуулсан байна.

Хэлтсийн албан бичгийн хагас жилийн эргэлтийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

Он	Ирсэн бичиг			Явсан бичиг	Хэлтсийн даргын тушаал			Өргөдөл, гомдол
	Хариутай	Хариугүй	Нийт		А тушаал	Б тушаал	Нийт	
2019 оны жилийн эцэс	483	373	856	1393	21	14	35	95
2020 оны жилийн эцэс	650	600	1250	16000	19	7	26	95
2021 оны жилийн эцэс	550	231	781	1452	17	10	27	79

Албан бичгийн эргэлтийг харьцуулбал:



Иргэдээс ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь авч үзвэл:

- Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 23
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар - 27
- Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 22
- Албан хаагчтай холбоотой гомдол – 1
- Албан хаагчийн нийгмийн асуудал болон хүний нөөцтэй холбоотой асуудлаар – 6
- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 0

Өргөдөл, гомдол



9.ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ, ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

- 2021 оны жилийн эцсийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлийг цахим хуудсанд 169, фэйсбүүк хуудсанд 214 удаа байршуулан түгээн дэлгэрүүлэн ажилласан ба иргэдээс ирүүлсэн нийт 98 чатанд хариу өгч асуудлыг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлүүлэн ажилласан.
- Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаархи инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж хэвшсэн ба тайлант хугацаанд 11 удаа мэдээлэл бэлтгэн олон нийтэд мэдээллэж ажиллалаа.
- Байгууллагын 70388618 дугаарыг хэрэглэгчдэд амар хялбар болгох үүднээс 70381818 дугаараар сольж иргэдийн санал гомдлыг авч тухай бүрд нь хариуг хүргүүлэн ажиллаж байгаа ба тайлант хугацаанд 139 удаагийн дуудлаганд хариу өгч, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн
- 2021 оны 01 дүгээр сарын 11-нд “Түмний телевиз”-д төрийн бус байгууллагын тайлан ирүүлэлтийн талаар болон цаг үеийн байдлын талаарх мэдээлэл өгөв.
- 2021 оны 04 дүгээр сарын 19-нд “Хөвсгөл телевиз”-д Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан 2021 оны 07 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэх улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон тухай мэдээлэл өгөв.
- 2021 оны 05 дугаар сарын 18-нд Хөвсгөл аймгийн Их-Уул, Тариалан, Эрдэнэбулган суманд төрийн байгууллагын албан хаагчдад иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгөв.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, холбогдох журмуудын шинэлэг зохицуулалтын талаарх мэдээлэл, Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас гаргасан дүрсжүүлсэн гарын авлага мэдээллийг байгууллагын байранд байрлах дэлгэцээр гаргаж иргэдэд мэдээлэл түгээж байна.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд түгээх зорилгоор санал хүсэлтийн хайрцаг бүхий мэдээллийн самбарыг байгууллагын байрны үйлчилгээний зааланд байршуулан ажиллаж байна.
- Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан khuvsgul.burtgel.gov.mn, Хөвсгөл аймгийн улсын бүртгэлийн хэлтэс page хуудас, E-Mongolia-наас шаардлагатай мэдээлэл, лавлагаагаа авах боломжтой тухай, улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3-т хуульд заасны дагуу нээлттэй мэдээлэлтэй хэрхэн танилцах зэрэг зөвлөмжүүдийг хүргүүлэн ажиллав.
- Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим үйлчилгээний буланг бий болгосон. Цахим үйлчилгээний буланг үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлснээр цахим үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia “-ээс иргэд лавлагаа мэдээлэл авах, гадаад паспорт, иргэний үнэмлэх захиалах зэрэг үйлчилгээ авахаас гадна

иргэд интернэт банк, мобайл банк ашиглан үйлчилгээний хураамжаа тушааж баримтаа хэвлэн өгөх боломжоор хангагдсан. Цахим үйлчилгээний булангаар нийт 209 иргэн үйлчлүүлсэн байна.

- Хэлтсийн үйлчилгээний танхимд цахим буланг бий болгож үйлчилгээнд ашиглаж эхэлснээр иргэд интернэт банк ашиглан үйлчилгээний хураамжаа тушааж, нийт үйлчлүүлэгчийн 30 орчим хувь нь банк орохгүйгээр үйлчилгээний хураамжийн баримтыг хэвлэн өгөх нөхцөл боломж бүрдсэн.

10. СУРГАЛТ, СЕМИНАР БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭХЖҮҮЛЭХ

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2021 онд зохион байгуулсан 36 удаагийн онлайн болон танхимын сургалтанд хэлтсийн албан хаагчдыг чиглэл тус бүрээр хамруулсан.
- Хэлтсийн 2021 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн дагуу ковид-19 цар тахлаас шалтгаалан танхимын сургалт зохион байгуулах боломжгүй болсонтой холбогдуулан сумдын улсын бүртгэгч нарт 7 удаагийн цахим сургалт, 2021 оны 11 дүгээр сарын 19, 20-ны өдөр танхимын 1 удаагийн сургалтыг тус тус амжилттай зохион байгуулсан.
- 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах арга зүйч Б. Ганчимэгийг урин “Идэвхтэй хөдөлгөөн ба суугаа хэв маяг” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.
- 2021.02.23-онд Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газраас Холбооны бүгд найрамдах герман улсын Барут/Марк хотоос Мөрөн хотод хэрэгжиж буй “KCS-058-.BARUT/MARK-2020” төслийн хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах “Коронавируст /ковид-19/ халдвараас урьчилан сэргийлэх тандах, бэлэн байдал, хариу арга хэмжээ авах нь” сэдэвт сургалтанд нийт албан хаагчид хамрагдаж гэрчилгээ авлаа.
- 2021.04.25-нд “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний сургалтанд цахимаар хамрагдаж амжилттай төгсөн цахим гэрчилгээ авсан.
- 2021.05.19-нд аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сургалтанд нийт албан хаагчид хамрагдлаа.
- Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил, сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн сургалтыг 2021 оны 05 сарын 11-12 ны өдрүүдэд онлайн хэлбэрээр Хэлтсийн дарга Б.Эрдэнэбилэг Иргэний улсын бүртгэлтйн тасгийн дарга, Улсын ахлах бүртгэгч Б.Өлзийням, Тагнуулын хэлтсийн ажилтан Г.Түмэнжаргал нар удирдан зохион байгууллаа.
- Монгол улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар Хөвсгөл аймгийн 23 сум 1 тосгоны 129 хэсгийн хороонд ажиллах 130 итгэмжлэгдсэн ажилтанд зориулсан сонгуулийн ирц бүртгэлийн

программын дадлага олгох, эрх зүйн сургалтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн газрын дарга Т.Төгөлдөрөөр ахлуулсан, Баянзүрх дүүргийн Хяналтын улсын байцаагч Д.Оюунтүлхүүр, Мэдээлэл технологийн газрын ахлах мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, гэрээт ажилтан Т.Баасансүрэн нар удирдан халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн 2021 оны 05 сарын 30-31 ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

- 2021.09.02-03-ны хооронд Тагнуулын ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь хэлтсээс зохион байгуулсан Терроризмтэй тэмцэх зөвлөл, хамтын ажиллагааны зөвлөлийн 2021 оны орон нутаг дахь хамтарсан 2 өдрийн сургалтанд хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Насанбуян хамрагдсан.
- Тус хэлтсийн 2021 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Аймгийн засаг даргын тамгын газрын Архивын тасгаас “Баримт бичгийн стандарт”-ын дагуу сургалт авж хэлтсийн албан хаагчид хамрагдлаа.
- Хөвсгөл аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхээр төлөвлөсөн ажлын хүрээнд ERP системийг албан хэрэгцээнд ашиглах тухай сургалтанд хэлтсийн бичиг хэргийн ажилтан амжилттай хамрагдсан.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад зориулсан улсын бүртгэлийн багц хуулийн хэрэгжилттэй холбоотой сургалтыг 2021 оны 08 дугаар сарын 20,21-ний өдрүүдэд хэлтсийн зүгээс амжилттай зохион байгуулж, тус хэлтсийн 36 албан хаагч амжилттай хамрагдаж, багц хууль, холбогдох дүрэм журам, улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын цахим системийн талаар мэдээлэл авсан.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамжийн хөгжүүлэлтийг танилцуулах, системд шинээр нэмэгдсэн өгөгдөл, түүнийг удирдан ажиллуулах зэрэгт мэдлэг, мэдээлэл, дадлага олгох сургалтанд тус хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан Э.Нарантуяа хамрагдлаа.
- 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Удирдах ажилтны” зөвлөгөөнд тус хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнзул хамрагдлаа.
- 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдөр Далай ван сургуулийн багш Б.Чинзоригийг хүвлээн авч, монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүй, төлөвлөгөө тайлаан бичих заавар сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж, хэлтсийн бүх албан хаагчид хамрагдсан.


- 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр ГХБХБГ-с цахим системд шилжсэнтэй холбогдуулан мэдээлэл зохион байгуулж, албан хаагчдыг мэдээ мэдээллээр хангасан.
- 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдөр АЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас зохион байгуулсан тайлан, төлөвлөгөө бичих тухай сургалтанд хэлтсийн бичиг хэргийн ажилтан хамрагдсан.
- 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр АЗДТГ-н хөдөлмөр хамгааллын зөвлөлөөс зохион байгуулсан “Нэн тэргүүнд ХАБЭА” сургалт, зөвлөгөөнд хэлтсийн хөдөлмөр хамгааллын орон тооны бус ажилтан Б.Оюунцэрэн хамрагдаж сертификат авсан.

12. ШИНЭЛЭГ АЖЛЫН ТУХАЙ

Ковид-19 цар тахал вирусн улмаас иргэдтэй уулзаж сургалт, зөвлөгөө, мэдээлэл хийх боломж муу байгаа учраас цахим орчин ашиглан иргэдэд мэдээлэл хүргэхийг зорьж ажиллаж байна. Галт сумын улсын бүртгэгч П.Даваадулам нь ЗДТГ-ын цахим хуудас болон албан байгуулагуудын дотоод цахим хуудсанд өөрийн бэлтгэсэн зөвлөмж, санамжаа тогтмол байршуулан иргэдээс ирүүлсэн асуултанд утсаар болон сэтгэгдэлд хариулт өгөн ажиллаж байна. Хэрэгжүүлж буй ажлуудаас дурьдвал:






1. “Улсын бүртгэгч зөвлөж байна” нэртэй булан ажиллуулж иргэний улсын бүртгэлийн 8-н төрлийн бүртгэл, эд хөрөнгийн бүртгэлийн бүрдүүлэх материал, хугацаа анхаарах асуудлыг тусгасан хуудас бэлтгэн мэдээлж байна. Нийтдээ 10 төрлийн хуудас бэлтгэн нийтэлсэн цаашид нэмэгдүүлэх зорилготой байгаа.

3





НИЙТЭЛСЭН МЭДЭЭЛЭЛ

2. Сар бүрийн бүртгэлийн тоон мэдээг бэлтгэн цахим орчинд байршуулж иргэдийг мэдээллээр хангаж байна.



3. Powtoon болон powerpoint ашиглан иргэдийн хамгийн ихээр асуудаг бүртгэл болох иргэний шилжилт хөдөлгөөн, иргэний үнэмлэх захиалах талаар, үл хөдлөхийн гэрчилгээ авах, газар өмчлөх талаар видео бэлтгэн Галт сумын цахим хуудсуудад байршуулсан.





4. Ерөнхий боловсролын сургууль, Хүн эмнэлэг, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв зэрэг албан байгууллагуудад Улсын-бүртгэл лавлах нэртэй Улсын бүртгэлийн 3-н бүртгэлийн танилцуулга, бүрдүүлэх материал зэргийг багтаасан хавтас бэлтгэн хүргүүллээ.



5. E-Mongolia сайт ашиглан лавлагаа авах, иргэний цахим үнэмлэх болон гадаад паспорт дахин захиалах талаар иргэдэд мэдээлэл хүргэж 2 иргэн гэсэн үнэмлэхээ 3 иргэн гадаад паспортаа захиалуулж авсан байна. ЗДТГ-ын албан хаагчид багийн засаг дарга нар болон ЕБС-ийн багш ажилчдад Е-



6. 11 сарыг Бүртгэлийн ажилтны өдрийг угтан Шинэлэг-Бүтээлч ажлын сар болгон зарлаж иргэдэд мэдээлэл хүргэх 7 хоногийн аян зарлаж ЗДТГ-ын угтах үйлчилгээнд ажиллаж ЗДТГ-аар үйлчлүүлж буй нийт 90 гаруй иргэнд улсын бүртгэлийн гарын авлага, мэдээ, мэдээлэл хүргэж ажиллаа.




7. Монгол улсын иргэний Андгай өргөх ёслолыг ёслол төгөлдөр зохион байгуулж 61 хүүхэд оролцлоо. Оролцсон 16 настай хүүхдүүдэд Андгайны хуудас гардуулж, 3 азтан тодруулж эрхийн бичгийн эзнийг тодруулсан. Мөн 16 настнуудыг дунд шүлгийн уралдаан зарлаж шалгарсан 4 сурагчид өргөмжлөл мөнгөн шагнал гардууллаа.





8. Тариалан сумын улсын бүртгэгч “ ИРГЭНИЙ БИЧИГ БАРИМТЫН ЗӨРЧИЛГҮЙ СУМ” 10 хоногийн аян 2021.11.03-ны өдрөөс 2021.11.13-ны өдрийг дуустал амжилттай зохион байгуулан ажилласан байна.



Аяны хүрээнд :

- 2016 онд Тариалан сумаас Дархан-Уул аймаг руу хасалтаа хийлгэсэн боловч очиж бүргүүлээгүй 1 иргэнийг бүртгэж иргэний үнэмлэх захиалж бичиг баримттай болгосон мөн Түнэл сумаас 2013 онд Тариалан суманд шилжихээр хасалтаа хийлгэсэн ч ирж бүртгүүлээгүй иргэнийг утсаар холбогдож мэдээлэл өгч хөдөөнөөс орж ирж бүртгүүлэхийг зөвлөж мэдээлэл өгч ажиллалаа.
- Тариалан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 01 сарын 30-ны өдрийн №03 дугаар тогтоолоор сумын төвийг 2 багт хувааж иргэдийг шинэ баг руу шилжилт хөдөлгөөн хийлгэхийг уриалж байгаа билээ. Аяны хугацаанд Мандал багаас Бадрах баг руу 3 том хүн 1 хүүхэд шилжилт хийлгэв.
- Аяны хугацаанд 25,45 насны сунгалт хийлгэх хугацаа хэтэрсэн 6 иргэний үнэмлэхний сунгалт хийж Мөн иргэний цахим үнэмлэхээ гэж үрэгдүүлсэн 2 иргэн цахим үнэмлэхээ захиалав.

4. Хүүхдийнхээ төрсний гэрчилгээг гэмтээж үрэгдүүлсэн 2 иргэнд төрсний гэрчилгээ дахин олгов.
5. “Сайн засаглал” төслийн хүрээнд амьжиргааны баталгаажих түвшин доогуур иргэний үнэмлэх захиалах боломжгүй иргэдийн судалгааг авч 7 иргэнийг үнэ төлбөргүй бичиг баримттай болгосон бөгөөд 443,100 төгрөгний санхүүжилт зарцуулсан байна.
6. Гэрлэсний бүртгэл 6 бүртгэл хийсэн бөгөөд 3 залуу гэр бүлийн гэрчилгээг ёслол хүндэтгэлийн өргөөнд гардуулж өгөв.



7. Иргэд бүртгэл авахаар ирэхдээ бүрдүүлэх бичиг баримтыг дутуу бичиж авах, бүрэн ойлгохгүйгээс болж дутуу материалтай ирж дахин дахин буцах чирэгдэл гардаг тул тэдэнд ойлгомжтой байхаар бүрдүүлэх маягтуудыг хэвлэж тарааж өгөхөөр бэлтгэсэн. Энэ нь иргэдэд их таалагдсан хялбар үйлчилгээ болов.

ДУГНЭЛТ

Тус хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх болон 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх талаар онцгой анхаарч холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн УБЕГ-т тайлагнах холбогдох эрх зүйн акт, тайлан мэдээг сар, улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан байна.

2021 онд батлагдсан төсвөөр эхний 11 байдлаар 623 020 300 төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоос 270 515 568 төгрөгийг оруулж улсын төсөвт төвлөрүүлээд байна.

2021 оны МУ-н Ерөнхийлөгчийн сонгуулиар 116 135 400.00 төгрөгийн санхүүжилт хийгдэн, батлагдсан хуваарийн дагуу зарцуулан ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж, төлөвлөгөөт ажлуудаа амжилттай зохион байгуулж байна. Тайлант хугацаанд ковид-19 цар тахалтай холбогдуулан зарим ажлууд онлайнаар хийгдэж, зарим ажлууд огт хийгдээгүй байна.

2021 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хяналтандаа авч хэрэгжилтийг ханган ажиллаж, 2021 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн явцын хяналт шинжилгээний үнэлгээний зөвлөмжийн дагуу, ажил эрчимжүүлэх ажлын хэсгийг хэлтсийн даргын тушаалаар байгуулан эрчимжүүлэх шаардлагатай 5н арга хэмжээг зорилтот түвшинд хүргэхээр хяналтандаа авч, холбогдох ажлуудыг амжилттай зохион байгуулан ажиллалаа.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Т.ЛХАГВАДОРЖ

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

П.ГАНЗОРИГ

Мөрөн 2021.12.06